

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ФАТФ ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ

Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны чухал ач холбогдлыг хүлээн зөвшөөрч “Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага” (Financial Action Task Force буюу ФАТФ) нь доорх зөвлөмжүүдийг гаргасан бөгөөд эдгээр нь мөнгө угаахтай тэмцэх ФАТФ Дөчин зөвлөмжтэй нийлээд терроризм, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх, илрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх анхан шатны арга хэмжээ болж байгаа юм.

I. НҮБ-аас гаргасан конвенц, тогтоолд нэгдэн орох, тэдгээрийг дагаж мөрдөх

Улс орон бүр 1999 оны НҮБ-ын Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенцид нэгдэн орж, түүнийг дагаж мөрдөх талаар нэн даруй арга хэмжээ авна.

Мөн улс орнууд террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхтэй холбогдон гарсан НҮБ-ын тогтоолууд, тэр дундаа НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн 1373 дугаар Тогтоолыг нэн даруй дагаж мөрдөнө.

II. Терроризмыг санхүүжүүлэх болон түүнтэй холбоотой мөнгө угаах үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцох

Улс орон бүр терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагыг санхүүжүүлэх үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцно. Ингэхдээ, эдгээр хэргийг мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэрэгт тооцох шаардлагатай.

III. Террористуудын хөрөнгийг хөдөлгөөнгүй болгох, хураан авах

Улс орон бүр терроризм болон террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой НҮБ-ын тогтоолуудын дагуу террорист этгээд болон терроризм, террорист байгууллагыг санхүүжүүлдэг этгээдийн эд хөрөнгө, мөнгийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авна.

Түүнчлэн улс орнууд эрх бүхий байгууллагад терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагыг санхүүжүүлсэнээс олсон орлого, санхүүжүүлэхэд ашиглаж байгаа буюу ашиглахаар завдсан эсхүл түүнд зориулсан хөрөнгийг хуулийн дагуу битүүмжлэх, хураан авах эрхтэй байх, эсхүл хуулиар ийм эрх олгох асуудлыг авч үзэх шаардлагатай.

IV. Терроризмтэй холбоотой сэжигтэй гүйлгээг мэдээлэх

Мөнгө угаахтай тэмцэх үүрэг хүлээсэн санхүүгийн байгууллага болон бусад бизнес эрхлэгч этгээд нь хөрөнгө, мөнгийг терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагатай холбоотой эсхүл холбоотой байж магадгүй гэж үзсэн, эсхүл сэжиглэх хангалттай үндэслэл байгаа бол эрх бүхий байгууллагад энэ сэжгийн тухай нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

V. Олон улсын хамтын ажиллагаа

Улс орон бүр терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагыг санхүүжүүлэхтэй холбоотой эрүүгийн, иргэний, захиргааны мөрдөн шалгалт, хүсэлт, шүүх үйл ажиллагаанд харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр бусад арга хэрэгслийг үндэслэн бусад орнуудтай хамтран ажиллаж, бүхий л бололцоогоор харилцан туслалцаа үзүүлнэ.

Улс орнууд терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдийг газар нутагтаа орогнуулахгүй байх бүх бололцоотой арга хэмжээг авах бөгөөд боломжтой бол ийм этгээдийг шилжүүлэн өгөх арга хэмжээг тогтооно.

VI. Бусад төрлийн мөнгөн гуйвуулга

Улс орон бүр мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг албан бус сүлжээ гэх мэт мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, төлөөлөгч, болон хуулийн этгээдийг бүртгэдэг эсхүл лиценз олгодог байх хэрэгтэй бөгөөд тэдгээр нь банк болон банк бус санхүүгийн байгууллагуудын нэгэн адилаар ФАТФ Зөвлөмжийг дагаж мөрдөнө. Улс орнууд дээрх үйл ажиллагааг хууль бусаар явуулж байгаа хувь хүн, хуулийн этгээдэд захиргааны, иргэний болон эрүүгийн хариуцлага ногдуулах шаардлагатай.

VII. Цахим шилжүүлэг

Улс орнууд санхүүгийн байгууллага, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас цахим шилжүүлэг хийхдээ мөнгө шилжүүлж буй харилцагчийн талаарх мэдээлэл (нэр, хаяг, дансны дугаар) болон холбогдох гүйлгээний утгыг үнэн зөв бүрдүүлж авахыг шаардах бөгөөд эдгээр мэдээлэл нь шилжүүлэгтэй хамт шат дамжлага бүрт дагалдан явах шаардлагатай.

Санхүүгийн байгууллага болон мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг байгууллага нь харилцагчийн мэдээлэл (нэр, хаяг, дансны дугаар) бүрэн бус, сэжигтэй мөнгөн шилжүүлгийг тусгайлан шалгаж, хянах арга хэмжээ авна.

VIII. Ашигийн бус байгууллага

Улс орнууд терроризмыг санхүүжүүлэхэд хууль бусаар ашиглагдаж болох хуулийн этгээдийг зохицуулдаг хууль тогтоомжийг хянан үзэх шаардлагатай. Ялангуяа, ашигийн бус байгууллага нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд өртөх эрсдэлтэй бөгөөд

улс орнууд энэ төрлийн байгууллага нь хууль бусаар дараахь тохиолдолд ашиглагдах бололцоогүй байх талаар арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

- (i) хууль ёсны байгууллагын нэрэн дор террорист байгууллага нуугдах;
- (ii) терроризмыг санхүүжүүлэх болон хөрөнгө, мөнгийг саатуулах арга хэмжээ авахаас зайлсхийх зорилгоор хуулийн этгээдийг ашиглах;
- (iii) хууль ёсны үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгө, мөнгийг зохион байгуулалттай террорист байгууллагын үйл ажиллагаанд зориулахаар гуйвуулах, нуун далдлах.

IX. Бэлэн мөнгө тээвэрлэгчид

Улс орнууд мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгслийг хилээр бэлнээр нэвтрүүлж байгааг илрүүлэх декларацийн /мэдүүлэг бөглөх/ систем эсхүл мэдэгдэх системтэй байх шаардлагатай.

Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх болон мөнгө угаах зорилгоор мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгслийг тээвэрлэж байж болзошгүй гэж үзсэн, түүнчлэн зорчигч мэдүүлгээ худал мэдүүлсэн эсхүл мэдэгдсэн тохиолдолд эрх бүхий байгууллага зогсоох болон хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авах эрхтэй байх бололцоог хангана.

Улс орнууд зорчигч мэдүүлгээ худал мэдүүлсэн эсхүл мэдэгдсэн тохиолдолд үр дүнтэй, тохирсон болон урьдчилан сэргийлэх шийтгэлийн арга хэмжээ ногдуулна. Мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгслийг терроризмыг санхүүжүүлэх эсхүл мөнгө угаахтай холбоотой бол Зөвлөмж 3 болон Тусгай Зөвлөмж III-т заасны дагуу тухайн мөнгөн тэмдэгт болон төлбөр тооцооны хэрэгслүүдийг хураан авах хүртлэх арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг хуулийн хүрээнд шийдэх шаардлагатай.

ТАЙЛБАР
ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ II: ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ
БОЛОН ТҮҮНГЭЙ ХОЛБООТОЙ МӨНГӨ УГААХ
ҮЙЛ АЖИЛЛАГААГ ГЭМТ ХЭРЭГТ ТООЦОХ

Зорилго

1. Тусгай зөвлөмж II (ТЗ II) нь улс орнуудыг терроризмыг санхүүжүүлж байгаа этгээдийг мөрдөн шалгах болон эрүүгийн хариуцлагад татах эрх зүйн чадамжтай байлгах зорилготой. Тусгай зөвлөмж II-ын нөгөө нэг зорилго бол олон улсын терроризм ба мөнгө угаах үйл ажиллагааны нягт уялдаа холбоог харгалзан, түүнийг илүү тодорхойлохын тулд улс орнуудаас терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийг мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэрэгт хамруулахыг шаардах явдал юм. Терроризмыг санхүүжүүлэх үйлдлийг гэмт хэрэгт тооцохдоо 1999 оны¹ НҮБ-ын Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх конвенцийг суурь болгох шаардлагатай.

Тодорхойлолт

2. ТЗ II болон энэ Тайлбарт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

а) *Хөрөнгө* гэж ямар ч хэлбэрээр олж авсан байж болох бөгөөд хууль эрх зүйн ямар ч хэлбэртэй байж болох биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө; цахим болон тоон гэх мэт ямар ч хэлбэртэй байж болох эзэмших эрх болон эзэмшлийн хувиа баталсан хуулийн баримт бичиг, арга хэрэгсэл, үүнд банкны зээл, замын чек, банкны чек, төлбөрийн даалгавар, хувьцаа, үнэт цаас, бонд, вексел болон аккредитив багтах бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

б) *Террорист* гэж (i) террорист үйлдлийг шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан; (ii) террорист үйл ажиллагаанд хамтрагчаар оролцсон; (iii) террорист үйл ажиллагаа зохион байгуулсан болон бусдаар үйлдүүлсэн; эсхүл (iv) нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсхүл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан хувь хүнийг хэлнэ.

с) *Террорист үйл ажиллагаа* гэж дараах зүйлийг хэлнэ:

i. Дор дурдсан гэрээ хэлцэлд гэмт үйлдэл гэж үзсэн болон тодорхойлсон үйлдэл: Нисэх онгоцыг хууль бусаар булаан аваачих явдалтай тэмцэх тухай конвенц (1970), Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдалтай тэмцэх тухай конвенц (1971), Олон улсын хамгаалалтыг хүлээх хүмүүсийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шүүн цээрлүүлэх тухай конвенц (1973), Барьцаанд хүмүүсийг авахтай тэмцэх тухай конвенц (1979), Цөмийн материалыг

¹ НҮБ-ын энэ конвенц ТЗ II-ыг анх гаргасан 2001 оны 10 дугаар сард хүчин төгөлдөр болоогүй байсан учраас ТЗ-д шууд тусгагдаагүй байсан бөгөөд ФАТФ нь анх ТЗ II-ийг гаргахдаа Конвенцийн гэмт хэрэгт тооцох заалт, стандартыг дахин бататган сануулах зорилгоор оруулсан. 2003 оны 4 дүгээр сард энэ конвенц хүчин төгөлдөр болсон.

биечлэн хамгаалах тухай конвенц (1980), Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай протокол, Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдалтай тэмцэх тухай конвенцийн нэмэлт (1988), Далайн навигацгийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц (1988), Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол (1988), Алан хядах зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай конвенц (1997)

ii. Зэвсэгт мөргөлдөөнд идэвхтэй оролцоогүй иргэд болон бусад хүмүүсийн амийг хөнөөх болон биед нь хүнд гэмтэл учруулах үйлдэл нь зорилго болон агуулгаараа ард иргэдийг айлгах, төр засаг болон олон улсын байгууллагыг ямар нэгэн үйлдэл хийхэд хүргэх болон хийхээс татгалзуулахад чиглэсэн бусад үйлдэл.

d) *Терроризмыг санхүүжүүлэх* гэдэгт террорист үйлдэл, террорист болон террорист байгууллагыг санхүүжүүлэх багтана.

e) *Террорист байгууллага* гэж дор дурдсан үйлдлийг хийсэн бүх бүлэг террористуудыг хэлнэ: (i) террорист үйлдлийг шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан; (ii) террорист үйл ажиллагаанд хамтрагчаар оролцсон; (iii) террорист үйл ажиллагаа зохион байгуулсан болон бусдаар үйлдүүлсэн; эсхүл (iv) нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсхүл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах гэж байгааг мэдэж байсан.

Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн онцлог

3. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хөрөнгийг (a) террорист үйл ажиллагаа(нууд) явуулахад; (b) террорист байгууллагад; (c) террорист этгээдэд бүтнээр нь болон хэсэгчлэн хэрэглэгэхийг мэдсээр байж эсхүл хууль бусаар тэдэнд ашиглуулах зорилгоор шууд болон шууд бусаар, сайн дураараа бэлтгэн өгч эсхүл цуглуулж байгаа этгээдийг хамруулах шаардлагатай.

4. Терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааг зөвхөн туслах болон дэмжлэг үзүүлэх, оролдлого болон үгсэн хуйвалдах үйлдлийн үндсэн дээр гэмт хэрэгт тооцох нь энэ Зөвлөмжийг биелүүлэхэд хангалтгүй болно.

5. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хууль ёсны болон хууль бус эх үүсвэрээс олсон бүх хөрөнгө хамаарах шаардлагатай.

6. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт тооцохын тулд хөрөнгийг (a) террорист үйл ажиллагааг яг бодитоор үйлдсэн буюу үйлдэхийг завдахад ашигласан; эсхүл (b) тодорхой террорист үйлдэлтэй(үүдтэй) холбоотой байсан гэж шаардахгүй байх шаардлагатай.

7. Терроризмыг санхүүжүүлэхээр завдсан үйлдэл нь мөн гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

8. Дор дурьдагдсан үйлдлийг мөн гэмт хэрэгт тооцох шаардлагатай:

а) Энэ Тайлбарын 3 болон 7 дугаар зүйлд тусгасан үйлдэлд хамтрагчаар оролцсон бол;

б) Энэ Тайлбарын 3 болон 7 дугаар зүйлд тусгасан үйлдлийг зохион байгуулах болон бусдаар үйлдүүлсэн бол;

в) Энэ Тайлбарын 3 болон 7 дугаар зүйлд тусгасан үйлдлийг нэгэн зорилготой бүлэг этгээд гүйцэтгэхэд туслалцаа үзүүлсэн бол. Ийм туслалцаа нь санаатай үйлдэл бөгөөд (i) энэ бүлгийн үйл ажиллагаа болон зорилго нь терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бөгөөд бүлгийн гэмт хэргийн үйл ажиллагаа болон зорилгыг дэмжих зорилгоор, (ii) бүлгийг терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явуулахыг мэдсээр байж үйлдсэн бол.

9. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

10. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь тухайн гэмт хэрэг(үүд)-ийг үйлдсэн гэж сэжиглэгдэж байгаа этгээд террорист үйл ажиллагаа явагдсан/явагдах болон террорист этгээд(үүд)/байгууллага(ууд) байрлаж байгаа улсаас өөр улсад байрлаж байгаагаас үл хамааран гэмт хэрэгт тооцогдох шаардлагатай.

11. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн санаатайгаар үйлдэх хүчин зүйлийг гэмт хэргийн объектив бодит хүчин зүйлсээс гарган авахыг хуулийн дагуу зөвшөөрөх шаардлагатай.

12. Терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хуулийн этгээдийг хамруулах шаардлагатай. Энэ боломжгүй бол (үндэсний хууль тогтоомжийн суурь зарчмын дагуу) иргэний болон захиргааны хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

13. Тухайн оронд олон төрлийн хариуцлагын тогтолцоо байдаг бол хуулийн этгээдэд терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт холбогдуулан эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь хуулийн этгээдэд эрүүгийн, иргэний болон захиргааны журмаар давхар хариуцлага хүлээлгэхээр хэрэг үүсгэхэд саад болох ёсгүй.

14. Терроризмыг санхүүжүүлсэн хувь хүн болон хуулийн этгээдэд үр дүнтэй, тохирсон болон урьдчилан сэргийлэх шийтгэлийн арга хэмжээ авч байх шаардлагатай.

ТАЙЛБАР

ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ III: ТЕРРОРИСТУУДЫН ХӨРӨНГИЙГ ХӨДӨЛГӨӨНГҮЙ БОЛГОХ, ХУРААН АВАХ

Зорилго

1. ФАТФ Тусгай Зөвлөмж III нь хоёр үүрэг агуулсан байдаг. Нэгдүгээрт улс орнуудыг холбогдох НҮБ-ын Тогтоолуудын дагуу терроризмтэй холбоотой хөрөнгө болон бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгох болон шаардлагатай бол битүүмжлэх арга хэмжээ авахыг шаардсан. Тусгай Зөвлөмж III-ын хоёр дахь үүрэг нь улс орнуудыг эрх бүхий байгууллага, шүүхийн шийдвэр болон бусад арга хэрэгслийг ашиглан терроризмтэй холбоотой хөрөнгө болон бусад эд зүйлсийг битүүмжлэх, хураан авах арга хэмжээ авахыг шаарддаг байна.

2. Эхний шаардлагын зорилго нь терроризмтой холбоотой хөрөнгө болон бусад эд зүйлсийг тодорхой үндэслэл, учир шалтгаан, мөн уг хөрөнгө нь террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхэд ашиглагдаж болзошгүй гэж үзэх итгэл, үнэмшил эсхүл сэжгийн үндсэн дээр хөдөлгөөнгүй болгоход оршино. Хоёр дахь шаардлагын зорилго нь хөрөнгө болон бусад эд зүйлсийг террористууд болон террорист үйл ажиллагаатай холбоотой болохыг хангалттай үндэслэлээр тогтоосон үед террористуудаас энэ хөрөнгө болон бусад эд зүйлсийг хураан авах явдал юм. Эхний зорилго нь урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн бол дараагийг нь ерөнхийдөө урьдчилан сэргийлэх, шийтгэхэд чиглэгдсэн байна. Энэ хоёр шаардлага террорист болон террорист сүлжээний дэд бүтэц, үйл ажиллагаа болон хийхээр төлөвлөсөн террорист үйлдлийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Хамрах хүрээ

3. Тусгай Зөвлөмж III-ын эхний шаардлагын хувьд, НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхтэй холбоотой S/RES/1267(1999) тогтоол болон түүнийг дагалдан гарсан тогтоолууд², S/RES/1373(2001) болон террористын хөрөнгийг хөдөлгөөнгүй болгох, шаардлагатай тохиолдолд битүүмжлэх тухай заасан тогтоолуудад нэмэлт болох зорилготой юм. Тусгай Зөвлөмж III-д заасан үүрэг, хариуцлагын аль нь ч эрүүгийн, иргэний болон захиргааны, мөрдөн шалгах ажиллагааны болон бусад ажиллагааны³

² S/RES/1267(1999) тогтоол гарахдаа нэг жилийн хугацаатай гарсан. НҮБ нь S/RES/1267(1999) тогтоолын зүйлийг боловсронгуй болгох, өргөжүүлэх зорилгоор хэд хэдэн цуврал тогтоолыг гаргасан. Дагалдан гарсан тогтоолууд гэж анхны эх S/RES/1267(1999) тогтоолын үргэлжлэл бөгөөд шууд хамааралтай гарсан тогтоолыг ойлгоно. Энэхүү тайлбар бичгийг гаргах үед эдгээр тогтоолд S/RES/1333(2000), S/RES/1363(2001), S/RES/1390(2002), S/RES/1455(2003) багтаж байсан болно. Уг тайлбар бичигт S/RES/1267(1999) гэсэн нэр томъёо нь S/RES/1267(1999) болон түүнийг дагалдан гарсан тогтоолууд гэдгийг хэлж байгаа болно.

³ Жишээ нь, НҮБ-ын Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц (1988) болон НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (2000)-ийн аль аль нь үндэстэн дамнасан

хүрээнд хөрөнгө болон бусад эд зүйлстэй холбоотой, одоо мөрдөгдөж буй арга хэмжээ, үүрэг, хариуцлагыг орлох зорилгогүй гэдгийг энд онцлон тэмдэглэх нь зүйтэй. Харин Тусгай Зөвлөмж III нь террорист бүлэглэлүүдийн мөнгө болон бусад эд зүйлсийн урсгал, зарцуулалтыг зогсооход онцгой чухал үүрэг гүйцэтгэх урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гол анхаарлаа хандуулдаг.

4. S/RES/1267(1999) болон S/RES/1373(2001) тогтоол нь хөрөнгө болон бусад эд зүйлсийг нь хөдөлгөөнгүй болгох хувь хүн, этгээд болон уг жагсаалтыг гаргах эрх бүхий байгууллага, хэрэгжүүлэлт зэргээр ялгаатай байна.

5. S/RES/1267(1999) ба түүнийг дагалдан гарсан тогтоолууд нь улс орнуудыг Аль-Каида, Талибан, Осама Бин Ладен болон НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн 1267 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан НҮБ-ын Аль-Каида болон Талибаны Санкцийн Зөвлөлөөс (Аль-Каида болон Талибаны Санкцийн Зөвлөл) гаргасан жагсаалтанд орсон тэдгээртэй холбоотой хувь хүн, этгээдийн эзэмшдэг эсхүл хянадаг хөрөнгө болон бусад эд зүйлс, тэдгээрийн болон тэдгээрийн нэрийн өмнөөс эсхүл тэдний удирдлаган дор үйл ажиллагаа явуулдаг этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг хөрөнгө болон бусад эд зүйлсээс гарал үүсэлтэй хөрөнгө, мөнгийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авахыг, мөн эдгээр хөрөнгө болон бусад эд зүйлсийг дээрх этгээдүүдэд болон өөрийн орны иргэн болон тухайн улсад амьдарч байгаа хэнд ч шууд болон шууд бусаар ашиглуулахгүй байхыг үүрэг болгосон байна. Аль-Каида болон Талибаны Санкцийн Зөвлөл нь S/RES/1267(1999) тогтоолын дагуу мөнгө болон бусад хөрөнгийг нь хөдөлгөөнгүй болгох хувь хүн, этгээдийг жагсаалтыг гаргах эрх, үүрэг бүхий байгууллага юм. НҮБ-ын гишүүн орон бүр S/RES/1267(1999) тогтоолын дагуу Аль-Каида болон Талибаны Санкцийн Зөвлөл⁴-өөс гаргасан жагсаалтанд орсон хувь хүн, этгээдийн хөрөнгийг хөдөлгөөнгүй болгох үүрэг хүлээдэг.

6. S/RES/1373(2001) тогтоол нь улс орнуудыг⁵ террорист үйл ажиллагаа явуулсан, явуулахыг завдсан, эсхүл террорист үйл ажиллагаа явуулахад оролцсон болон тусламж, дэмжлэг үзүүлсэн хувь хүмүүсийн; тэдгээрийн шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг хуулийн этгээдийн; тэдгээрийн нэрийн өмнөөс болон тэдний удирдлаган дор үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээдийн мөнгө болон бусад хөрөнгийг, түүнчлэн дээрх хүмүүс болон тэдгээртэй хамтрагч хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг эсхүл удирдан захирдаг хөрөнгө болон бусад эд зүйлсээс гарал үүсэлтэй болон тэндээс олсон хөрөнгө, бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгохыг шаардсан. Улс орон бүр эдгээр хөрөнгө болон бусад эд зүйлсийг нь хөдөлгөөнгүй болгох хувь хүн, хуулийн этгээдийг тодорхойлж, нэрсийг нь гаргах эрхтэй байна. Түүнчлэн, улс орнуудын хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлэхийн тулд, бусад орны хөдөлгөөнгүй болгох арга хэмжээг судлаж, шаардлагатай тохиолдолд өөрийн улсад хэрэгжүүлэх арга хэмжээ авч болно. Хэрэв хүсэлт гаргасан улс нь (i) тусгай албан мэдэгдэл болон бусад харилцааны хэлбэрээр мэдэгдсэн; (ii) хүсэлт хүлээн авагч улсын холбогдох хууль

гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд хөдөлгөөнгүй болгох, битүүмжлэх, болон хураан авах үүргийг багтаасан байдаг. Эдгээр үүргүүд нь S/RES/1267(1999), S/RES/1373(2001) болон Тусгай Зөвлөмж III-т заасан үүргүүдээс салангид, тусдаа байна.

⁴ НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл нь НҮБ-ын Дүрмийн VII дугаар зүйлийг баримтлан үйл ажиллагаа явуулж байгаа бол гаргасан тогтоолуудыг НҮБ-ын бүх гишүүн орнууд дагаж мөрдөх шаардлагатай.

⁵ НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөл нь S/RES/1373(2001) тогтоолыг НҮБ-ын Дүрмийн VII дугаар зүйлийг баримтлан гаргасан (өмнөх тайлбарыг үзнэ үү).

тогтоомжийн дагуу хүсэлт тависан, холбогдох тухайн хүнийг террорист гэж үзэх, терроризм болон террорист байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлсэн гэдгийг сэжиглэж байгаа, ингэж үзэх хангалттай үндэслэлтэй бол хүсэлт хүлээн авсан улс хүсэлтэд заасан этгээдийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгоно.

Нэр томъёоны тодорхойлолт

7. Тусгай Зөвлөмж III болон энэхүү Тайлбар бичигт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- a) *Хөдөлгөөнгүй болгох* гэж шүүхийн буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр, хөдөлгөөнгүй болгох арга механизмын дагуу шийдвэр хүчинтэй байх хугацаанд тухайн хөрөнгө болон бусад эд зүйлсийг шилжүүлэх, өөрчлөх, өөр хүний эзэмшилд өгөх, хөдөлгөхийг хориглохыг хэлнэ. Хөрөнгө нь хөдөлгөөнгүй болгох үед тухайн хөрөнгөөс хувь эзэмшдэг хувь хүн, этгээдийн өмч хэвээр байх бөгөөд хөрөнгө хөдөлгөөнгүй болгох механизмын дагуу шийдвэр гарахаас өмнө дээрх хувь хүн, этгээдийн томилсон санхүүгийн байгууллага эсхүл тэдгээрийн байгуулсан бусад гэрээ, хэлэлцээрийн хөрөнгө захиран удирдах эрх хэвээр байна.
- b) *Битүүмжлэх* гэж шүүхийн буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр, битүүмжлэх журмын дагуу тухайн хөрөнгө болон бусад эд зүйлсийг шилжүүлэх, өөрчлөх, өөр хүний эзэмшилд өгөх, хөдөлгөхийг хориглохыг хэлнэ. Гэхдээ хөдөлгөөнгүй болгохоос ялгаатай нь битүүмжлэлийн үед тухайн хөрөнгө болон бусад эд зүйлсийг шүүх буюу эрх бүхий байгууллага хяналтандаа авдаг. Битүүмжлэгдсэн хөрөнгө болон бусад эд зүйлс нь битүүмжлэх хугацаанд тэдгээрээс хувь эзэмшдэг хувь хүн, этгээдийн өмч хэвээр байх боловч ихэнхдээ шүүх буюу эрх бүхий байгууллага нь уг битүүмжлэгдсэн хөрөнгийн эзэмшил, захиргаа, болон менежментийг хяналтандаа авдаг.
- c) *Хураан авах* гэж шүүхийн буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрээр хөрөнгө болон бусад эд зүйлсийг бүр мөсөн хураан авахыг хэлнэ. Ингэхдээ хураан авах арга хэмжээ нь тухайн хөрөнгө болон бусад эд зүйлсийг эзэмших эрхийг улсад шилжүүлэх шүүхийн буюу захиргааны арга хэрэгсэлээр дамжин хэрэгжинэ. Энэ тохиолдолд хөрөнгийг хураан авах үед уг хөрөнгөөс хувь эзэмшиж байсан хувь хүн, хуулийн этгээд нь хураалгасан хөрөнгийг өмчлөх эрхээ алдана.⁶
- d) *Хөрөнгө болон бусад эд зүйлс* гэж ямар ч хэлбэрээр олж авсан байж болох бөгөөд хууль эрх зүйн ямар ч хэлбэртэй байж болох биет болон биет бус, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө; цахим болон тоон гэх мэт ямар ч хэлбэртэй байж болох

⁶ Хураах шийдвэр нь ихэвчлэн гэмт хэргийн ял шийтгэлтэй холбоотой, эсхүл хураалгасан хөрөнгийг хууль зөрчиж олсон болон хууль зөрчихөд ашиглахад зориулагдсан гэж үзсэн шүүхийн шийдвэртэй холбогдсон байдаг.

эзэмших эрх болон эзэмшлийн хувиа баталсан хуулийн баримт бичиг, арга хэрэгсэл; банкны зээл, замын чек, банкны чек, төлбөрийн даалгавар, хувьцаа, үнэт цаас, бонд, вексел болон аккредитив, хүү, ноогдол ашиг болон бусад орлого, эсхүл тэдгээрээс олсон болон хуримтлуулсан орлого зэрэг хөрөнгө болон бусад эд зүйлсийг хэлэх бөгөөд бөгөөд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй болно.

- e) *Террорист* гэж (i) террорист үйлдлийг⁷ шууд болон шууд бусаар, хууль бусаар болон санаатайгаар үйлдэх, эсхүл үйлдэхийг завдах; (ii) террорист үйлдэл болон терроризмыг санхүүжүүлэхэд хамтран оролцсон; (iii) бусдыг террорист үйлдэл болон терроризмыг санхүүжүүлэхэд удирдан зохион байгуулах; эсхүл (iv) нэгдмэл зорилготой хэсэг бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа үйлдэхэд хувь нэмэр оруулсан, энэ оролцоо нь санаатай бөгөөд террорист үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн эсхүл тухайн бүлэг хүмүүсийг террорист үйл ажиллагаа явуулах болон терроризмыг санхүүжүүлэх гэж байгааг мэдэж байсан хувь хүнийг хэлнэ.
- f) *Терроризмыг санхүүжүүлж буй этгээд* гэж шууд болон шууд бусаар террорист үйлдэлийг гүйцэтгэхийн тулд түүнд бүхлээр болон хэсэгчлэн ашиглагдаж болох хөрөнгө болон бусад эд зүйлсийг цуглуулсан эсхүл өгсөн хувь хүн, бүлэг, бусад хуулийн этгээдийг, эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс болон тэдний удирдлаган дор ажилладаг хувь хүн, бүлэг, бусад хуулийн этгээдийг хэлнэ. Энд мөн террорист үйлдэл хийхэд бүхлээрээ болон хэсэгчлэн ашиглагдахыг нь мэдсээр байж, эсхүл түүнд зориулж хөрөнгө болон бусад эд зүйлсийг цуглуулсан болон өгсөн этгээдийг хамруулна.
- g) *Террорист байгууллага* гэж террористуудын шууд болон шууд бусаар эзэмшдэг эсхүл хянадаг хуулийн этгээд, бүлэг, бусад хуулийн этгээдийг хэлнэ.
- h) *Жагсаалтанд орсон хүмүүс* гэж S/RES/1267(1999) тогтоолын дагуу байгуулагдсан Аль-Каида болон Талибан Санкцийн Зөвлөлөөс гаргасан жагсаалтанд орсон хувь хүн, этгээдийг, эсхүл S/RES/1373(2001) тогтоолын дагуу улс орнуудын хүлээн зөвшөөрч, жагсаалтанд орсон хувь хүн, этгээдийг хэлнэ.

⁷ Террорист үйлдэл гэж дараах олон улсын гэрээний хүрээнд гэмт хэрэг гэмт үйлдэл гэж үзсэн болон тодорхойлсон үйлдэл: Нисэх онгоцыг хууль бусаар булаан аваачих явдалтай тэмцэх тухай конвенц, Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдалтай тэмцэх тухай конвенц, Дипломат ажилтнууд зэрэг олон улсын хамгаалалтыг хүлээх хүмүүсийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон шүүн цээрлүүлэх тухай конвенц, Барьцаанд хүмүүсийг авахтай тэмцэх тухай конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенц, Иргэний агаарын тээврийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн хууль бус явдалтай тэмцэх тухай конвенцид нэмэлт болох Олон улсын иргэний нисэхэд үйлчилж буй нисэх буудалд хүчирхийллийн хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай протокол, Далайн навигацийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай конвенц, Эх газрын хормойд байрлуулсан суурилуулах төхөөрөмжийн аюулгүй байдлын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай протокол, Алан хядах зорилгоор бөмбөг хэрэглэхтэй тэмцэх тухай конвенц, болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенц (1999).

- i) S/RES/1267(1999) тогтоол дахь *хугацаа алдалгүй* гэсэн холбоо уг нь угтаа Аль-Каида болон Талибан Санкцийн Зөвлөлөөс нэрсийн жагсаалтыг гаргаснаас хэдэн цагийн дотор гэсэн утгыг илэрхийлнэ. S/RES/1373(2001) тогтоол дахь *хугацаа алдалгүй* гэдгийг хувь хүн, хуулийн этгээдийг террорист гэж үзэх, терроризм болон террорист байгууллагыг санхүүжүүлж буй мөн гэж сэжиглэх, итгэх хангалттай үндэслэлтэй болонгуут гэж ойлгоно. Мөн *хугацаа алдалгүй* гэдэг нь террористтэй холбоотой хөрөнгө болон бусад эд зүйлсийг үрэгдэх эсхүл дүрвэхээс урьдчилан сэргийлэхийн тулд дэлхий нийтээр тэдгээрийн хөдөлгөөнийг маш богино хугацааны дотор таслан зогсоох, хориглох хамтарсан үйл ажиллагаа явуулах шаардлагын хүрээнд тайлбарлагдана.

Терроризмтэй холбоотой хөрөнгө болон бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгох

8. Улс орнууд Тусгай Зөвлөмж III-ийн урьдчилан сэргийлэх зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд зохих бүрэн эрхтийг олгох хэрэгтэй бөгөөд S/RES/1267(1999), S/RES/1373(2001) тогтоолуудын дагуу террорист болон терроризм, террорист байгууллагыг санхүүжүүлж буй этгээдийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох дараах стандарт, журмыг гаргах шаардлагатай:

- a) *Жагсаалтанд орсон хүмүүсийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох, цуцлах, тэдгээрийг худалдах, худалдан авахыг хориглох бүрэн эрх.* Улс орнууд хөрөнгө болон бусад эд зүйлсийг шилжүүлэх, өөрчлөх, өөр хүний эзэмшилд өгөх, хөдөлгөхийг хориглосон албадлагын арга хэмжээ авах хэрэгтэй. Террористын хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох, түүнийг цуцлах бүрэн эрх хангах дараах арга замууд байдаг:
- i. Холбогдох арга механизмын дагуу хөдөлгөөнгүй болгох, түүнийг цуцлах шийдвэр гаргах, зохион байгуулах, хэрэгжүүлэх эрхийг шүүх эсхүл эрх бүхий байгууллагад олгох, эсхүл тэдгээр байгууллагыг томилох,
 - ii. Шүүх, эрх бүхий байгууллагаас хөрөнгө болон бусад эд зүйлсийг нь хөдөлгөөнгүй болгох жагсаалтанд орсон хүмүүсийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хадгалж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг уг эд зүйлсийг нь хөдөлгөөнгүй болгохыг шаардах хууль батлах, хууль хэрэгжүүлээгүй хүмүүст хариуцлага тооцдог байх

Хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох болон цуцлах бүрэн эрх нь мөн терроризм болон террорист байгууллагыг санхүүжүүлж буй террорист этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг хөрөнгө болон бусад эд зүйлсээс гарал үүсэлтэй эсхүл уг хөрөнгөөс олсон мөнгө, бусад хөрөнгийг хамруулна.

Аль аргыг сонгосноос үл хамааран дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага бүхий эрх бүхий байгууллага нь тодорхой байх шаардлагатай.

Эрх бүхий байгууллага нь өөрийн орны иргэн болон тухайн улсад амьдарч байгаа бусад хувь хүн, хуулийн этгээд нь жагсаалтанд орсон хүмүүс,

террористууд; терроризмыг санхүүжүүлж буй этгээд; террорист байгууллага; тэдгээрийн этгээдийн шууд болон шууд бусаар эзэмшдэг болон хянадаг хуулийн этгээд; тэдгээр этгээдийн нэрийн өмнөөс болон удирдлаган дор нь үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, хуулийн этгээдэд тусалж дэмжих зорилгоор санхүүгийн болон бусад холбогдох үйлчилгээ, эдийн засгийн нөөц баялаг, хөрөнгө болон бусад эд зүйлс зэргийг бүхэлд нь болон хэсэгчлэн, шууд болон шууд бусаар өгөх, бэлдэхийг хориглоно.

- b) ***Хөдөлгөөнгүй болгох үйл явц.*** Улс орнууд доорх (с) хэсэгт заасан хөрөнгө болон бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй, холбогдох хувь хүн, хуулийн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр хөдөлгөөнгүй болгох үйл явцыг хэрэгжүүлнэ. Эдгээр хөрөнгө болон бусад эд зүйлсийг эзэмшиж буй хувь хүн, этгээд нь хуулийн дагуу тэдгээрийг хөдөлгөөнгүй болгох үүрэг хүлээдэг бөгөөд хэрэв энэхүү шаардлагын дагуу хуулийг хэрэгжүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээнэ. Гаргасан жагсаалтын талаарх мэдээллийг албан ёсоор хүлээн авах болон жагсаалтанд орсон хүмүүсийн хөрөнгө, бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох тухайн үйлдэл хоёрын дунд хугацаа алдах нь тэдгээр хүмүүст тодорхойлогдсон данс болон газраас мөнгө, бусад хөрөнгөө шилжүүлэх, зайлуулах хугацаа олгож, гаргасан жагсаалтын үр дүнг бууруулах сөрөг үр дагавартай. Ийм учраас хөдөлгөөнгүй болгох үйл явц нь (i) хөдөлгөөнгүй болгох механизмын дагуу уг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлэх хангалттай үндэслэл бий эсэхийг нэн даруй тодорхойлох, мөн (ii) хөдөлгөөнгүй болгох хангалттай үндэслэл байгааг тогтоосон даруй хөрөнгө болон бусад эд зүйлсийг хугацаа алдалгүй хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Улс орнууд арга хэмжээ авагдсан даруйд хөдөлгөөнгүй болгох механизмын дагуу авсан арга хэмжээний талаар санхүүгийн салбарт мэдээлэх үр дүнтэй, үр ашигтай системийг бий болгох шаардлагатай. Түүнчлэн, улс орнууд ялангуяа хөдөлгөөнгүй болгох механизмын дагуу хөдөлгөөнгүй болгохоор болсон тухайн хөрөнгө болон бусад эд зүйлсийг эзэмшиж байж магадгүй санхүүгийн байгууллага, хувь хүн, этгээдэд тодорхой заавар өгөх нь зүйтэй.
- c) ***Хөдөлгөөнгүй болгох, шаардлагатай бол битүүмжлэх хөрөнгө болон бусад эд зүйлс.*** Тусгай Зөвлөмж III-ын дагуу хөдөлгөөнгүй болгох хөрөнгө болон бусад эд зүйлс нь S/RES/1267(1999), S/RES/1373(2001) тогтоолд хөдөлгөөнгүй болгохоор заасан зүйлүүдийг хамарна. Эдгээр хөрөнгө болон бусад эд зүйлд жагсаалтанд орсон хүмүүсийн шууд болон шууд бусаар, бүхэлд нь болон хэсэгчлэн эзэмшдэг эсхүл хянадаг хөрөнгө мөн хамрагдана. НҮБ-ын Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын конвенц (1999) (Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенц (1999))-ийн дагуу хүлээсэн үүрэг ёсоор улс орнууд терроризм болон террорист байгууллагыг санхүүжүүлж буй, террористуудад ашиглагдаж буй, тэдэнд өгсөн, эсхүл ашиглагдахад бэлэн байгаа хөрөнгө болон бусад эд зүйлсийг холбогдох хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу тогтоож, шалган нотолсны үндсэн дээр тэдгээрийг хөдөлгөөнгүй болгох бөгөөд шаардлагатай бол битүүмжилнэ. Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенц (1999)-ийн дагуу хөдөлгөөнгүй болгох болон битүүмжлэх арга хэмжээ нь эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны болон бусад ажиллагааны хүрээнд хэрэгжиж болно. Тусгай Зөвлөмж III-ын дагуу хөдөлгөөнгүй болгох арга хэмжээг гуравдагч этгээдийн эрхийг хөндөлгүйгээр авч хэрэгжүүлнэ.
- d) ***Жагсаалтаас хасах болон хөдөлгөөнгүй болгох шийдвэрээ цуцлах үйл явц.*** Улс орнууд холбогдох хууль тогтоомжийн үндсэн зарчим болон олон улсын үүрэг хариуцлагын тогтолцоонд нийцсэн зарим болзолыг хангасан гэж үзвэл тэр даруй

жагсаалтаас хасах хүсэлтийг авч үзэх, тодорхой хугацааны дотор жагсаалтаас хасагдсан хувь хүн, этгээдийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох шийдвэрээ цуцалж буй талаар олон нийтэд ил тод арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. S/RES/1267(1999) тогтоолоор жагсаалтанд орсон хувь хүн, этгээдийн хувьд энэхүү арга хэмжээг S/RES/1267(1999) тогтоолын дагуу Аль-Каида болон Талибан Санкцийн Зөвлөл авч хэрэгжүүлнэ.

- e) **Хэн болохыг тогтоосны дараа хөдөлгөөнгүй болгох шийдвэрээ цуцлах.** Жагсаалтанд орсон хүмүүстэй ижил буюу төстэй нэртэй, хөдөлгөөнгүй болгох арга хэмжээнд санамсаргүй хамрагдсан хувь хүн, этгээдийн хувьд улс орнууд тухайн холбогдсон хувь хүн, этгээд нь жагсаалтанд орсон хүмүүс биш гэдгийг нотолсны дараа тодорхой хугацааны дотор тэдгээр хувь хүн, этгээдийн хөрөнгө болон бусад эд зүйлсийг хөдөлгөөнгүй болгох шийдвэрээ цуцлах олон нийтэд ил тод арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх шаардлагатай.
- f) **Тодорхой нөхцөл байдалд хөдөлгөөнгүй болгосон хөрөнгө болон бусад эд зүйлсийг зарцуулах эрх олгох.** Улс орнууд S/RES/1267(1999) тогтоолын дагуу хөдөлгөөнгүй болгох хөрөнгө болон бусад эд зүйлсийг шаардлагатай үндсэн зардал; зарим төрлийн зардал, төлбөр, үйлчилгээний хураамжийн төлбөр, эсхүл тусгай зардалд зарцуулагдах шаардлагатай гэж үзвэл⁸ Аль-Каида болон Талибан Санкцийн Зөвлөлөөс зөвшөөрөл авсны үндсэн дээр S/RES/1452(2002) тогтоолд заасан журмын дагуу зарцуулах эрхтэй байна. Мөн үүнтэй ижил шалтгаанаар, хэрэв хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ нь S/RES/1373(2001) тогтоолын дагуу хэрэгжиж байгаа бол улс орнууд тухайн мөнгө болон хөрөнгийг зарцуулах эрхтэй байж болно.
- g) **Давж заалдах.** Улс орнууд терроризмыг санхүүжүүлэх асуудлын хүрээнд хөдөлгөөнгүй болгох арга хэмжээнд хамрагдаж байгаа хувь хүн, хуулийн этгээд нь шүүх буюу эрх бүхий байгууллагад давж заалдах эрхтэй байх тогтолцоотой байх шаардлагатай.
- h) **Хариуцлага.** Улс орнууд 8(с)-д заасан хөрөнгө болон бусад эд зүйлсийг хадгалж байгаа хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн байгууллага нь хөдөлгөөнгүй болгох арга хэмжээг зохицуулдаг холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг биелүүлж буй эсэхийг үр дүнтэй хянах системийг бий болгох хэрэгтэй. Эдгээр хууль тогтоомж, журам, зааврыг дагаж мөрдөөгүй тохиолдолд иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулна.

Битүүмжлэх болон хураан авах

9. Улс орнууд шүүх, эрх бүхий байгууллагыг террористуудын хөрөнгө болон бусад эд зүйлсийг битүүмжлэх, хураан авах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг болгохын тулд ФАТФ Зөвлөмж 3-тай нийцүүлэн НҮБ-ын Мансууруулах эм болон сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг конвенц (1988)-ийн 5 дугаар зүйл, НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц (2000)-ийн 12, 14 дүгээр зүйл, болон Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай конвенц (1999)-ийн 8 дугаар зүйлд тус тус

⁸ Зарим төрлийн тусгай зардлуудыг S/RES/1452(2002) тогтоолын 1 дүгээр зүйлээс харна уу.

заасантай ижил төстэй, хууль эрх зүйн үндэслэлтэй арга хэмжээг бий болгох шаардлагатай.

ТАЙЛБАР

ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ VI: БУСАД ТӨРЛИЙН МӨНГӨН ГУЙВУУЛГА

Нийтлэг үндэслэл

1. Мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн систем нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглагдах эрсдэлтэй салбар юм. Тусгай Зөвлөмж VI-ийн гол зорилго нь бүх төрлийн мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг системд мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэн, мөнгөн урсгалын ил тод байдлыг нэмэгдүүлэхэд оршино. Үүнд ялангуяа уламжлалт санхүүгийн салбараас гадуур үйл ажиллагаа явуулдаг, одоогоор ФАТФ Зөвлөмжийг дагаж мөрддөггүй тэдгээр систем орох юм. Энэхүү Зөвлөмж болон Тайлбар нь холбогдох ФАТФ Зөвлөмжийн дагуу тогтоосон хууль, журмын хүрээнд албан болон албан бус бүх төрлийн мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээг хамруулах хэрэгтэйг онцолсон байна.

2. Тусгай Зөвлөмж VI нь дараах 3 гол зүйлсийг агуулна:

a. Улс орнууд албан болон албан бус бүх төрлийн мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээдийг бүртгүүлэх эсхүл лиценз авахыг шаардах;

b. Улс орнууд албан болон албан бус (5 дахь зүйлд заасанчлан) бүх төрлийн мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд нь ФАТФ Дөчин зөвлөмж (2003) (Зөвлөмж 4-16, 21-25)⁹ болон Найман Тусгай зөвлөмж (ялангуяа Тусгай Зөвлөмж VII)-ийг дагаж мөрдөхийг шаардах;

c. Улс орнууд албан болон албан бус бүх төрлийн мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээд нь бүртгэл, лицензгүй үйл ажиллагаа явуулсан болон холбогдох ФАТФ Зөвлөмжүүдийг дагаж мөрдөөгүй бол тохирсон хариуцлагын арга хэмжээ ногдуулах эрхтэй байх шаардлагтай.

Агуулга болон Хэрэглээ

3. Энэхүү зөвлөмжид хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4. *Мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ* гэж нэг газарт бэлэн мөнгө, чек, бусад мөнгөн төлбөр тооцооны хэрэгсэл болон үнэт зүйлсийг хүлээн авч, өөр газарт хүлээн авагч талд өөрийн харьяалагдах холбооны хэрэгсэл, мэдээлэл, шилжүүлэг болон клирингийн сүлжээ ашиглан хүлээн авсан хөрөнгө, мөнгөтэй ижил дүн бүхий бэлэн мөнгө

⁹ Энэхүү Тайлбарыг анх 1996 оны ФАТФ Дөчин зөвлөмжид зориулан гаргасан. ФАТФ Дөчин зөвлөмжийн дараагийн шинэчлэгдсэн хэвлэлт 2003 оны 6 дугаар сард гарах үед уг Тайлбар мөн шинэчлэгдсэн. Одоогийн Тайлбар нь 2003 оны ФАТФ Дөчин зөвлөмжид хамааралтай болно.

болон бусад хэлбэрээр төлбөрийг төлөх журмаар хийгдэх үйлчилгээг хэлнэ. Ийм системээр хийгдэж буй гүйлгээнд нэг буюу түүнээс олон зуучлагч, мөн гуравдагч буюу эцсийн төлбөр хүлээн авагч талууд оролцдог.

5. Мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээд санхүүгийн системээр дамжуулан албан ёсоор, эсхүл банк бус санхүүгийн байгууллага, бизнесийн байгууллагаар дамжуулан албан бусаар, эсхүл санхүүгийн систем (жишээ нь, банкны дансаар) болон санхүүгийн системээс гадуурх сүлжээгээр гэх мэтээр өөр бусад сүлжээ, арга хэрэгсэлийн аль алинаар дамжуулан үзүүлж болно. Зарим улс орнууд албан бус системийг гол төлөв *бусад төрлийн шилжүүлэг*, эсхүл *нууц буюу хууль бус (параллел) банкны систем* гэж нэрлэдэг. Ихэвчлэн эдгээр систем нь тодорхой газар зүйн байршилтай холбоотой байдаг учраас янз бүрийн нэрээр нэрлэгдэх нь бий. Заримаас нь дурьдвал: *хавала, хунди, фей-чиен, хар захын песо солих* гэх мэт.¹⁰

6. *Лиценз авах* гэж эрх бүхий албан байгууллагаас мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх хууль ёсны зөвшөөрөл авахыг хэлнэ.

7. *Бүртгүүлэх* гэж хууль ёсны дагуу үйл ажиллагаа явуулахын тулд эрх бүхий албан байгууллагад мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээг үзүүлэхээр бүртгүүлэх, эсхүл байгуулагдсан тухайгаа мэдэгдэхийг хэлнэ.

8. *Төлөөлөгч /агент/* нь мөн лиценз авах, бүртгүүлэх үүрэгтэй. Бизнес эрхлэгч нь өөрийн төлөөлөгчдийн жагсаалтыг хадгалан эрх бүхий албан байгууллагад гаргаж өгөх чадвартай байх ёстой. *Төлөөлөгч* гэж лицензтэй эсхүл бүртгүүлсэн, хууль ёсоор үйл ажиллагаа явуулдаг мөнгө шилжүүлэгчийн удирдлаган дор эсхүл гэрээний дагуу мөнгө болон хөрөнгийн шилжүүлэг хийдэг этгээдийг хэлнэ. (Жишээ нь, лиценз түрээслэгч, франчайз хүлээн авагч болон түрээслэгч)

Тусгай Зөвлөмж VI-ын Үйлчлэх Хүрээ

9. Тусгай зөвлөмж VI нь 4, 5 дугаар зүйлд тайлбарласан үйл ажиллагааг өөрийн эсхүл өөр этгээдийн (хувь хүн болон хуулийн этгээд) нэрийн өмнөөс үндсэн бизнесээ эсхүл бизнесийнхээ нэг хэсэг болгон явуулж байгаа бүх этгээдэд (хувь хүн болон хуулийн этгээд) үйлчилнэ.

10. Улс орнууд тухайн улсын нутаг дэвсгэрт санхүүгийн байгууллага (ФАТФ Дөчин зөвлөмж (2003)-д тодорхойлсоны дагуу)-аар бүртгэгдэж, лиценз авсан бөгөөд уг бүртгэл, лицензийн дагуу энэхүү Тайлбарын 4, 5-р зүйлд заасан үйл ажиллагааг эрхлэн явуулах зөвшөөрөл авсан, ФАТФ Дөчин зөвлөмж (2003) (тодруулбал, Зөвлөмж 4-16, 21-25) болон Найман Тусгай зөвлөмж (тодруулбал, Тусгай Зөвлөмж VII)-ийн дагуу холбогдох бүх үүрэг хариуцлагыг дагаж мөрдөх үүрэг хүлээсэн этгээдийг (хувь хүн болон хуулийн этгээд) дахин бүртгэх, тусад нь өөр лиценз өгөх, эсхүл тусгайлан өөр эрх бүхий байгууллагыг томилох шаардлагагүй.

¹⁰ Уг жишээнүүд нь аль нэг улс орны хувьд эдгээр систем нь хууль ёсны байдаг гэсэн үг биш юм.

Лиценз олголт, Бүртгэл, болон Хэрэгжүүлэлт

11. Улс орнууд лиценз олгодог, бүртгэдэг эрх бүхий байгууллагыг томилох, тавигдаж буй шаардлагуудыг байнга хянаж байх шаардлагатай. Мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлдэг этгээдийн ФАТФ Зөвлөмжийг (Найман Тусгай зөвлөмжийг оруулан) дагаж мөрдөх үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцдаг эрх бүхий байгууллага байх шаардлагатай. Мөн уг хэрэгжилтийг хангаж, хянадаг үр дүнтэй системтэй байх нь чухал. Энэхүү Тусгай зөвлөмжийн VI-ийн Тайлбар нь ФАТФ Зөвлөмж 23-тай нийцсэн болно.

Хариуцлага

12. Лицензгүй эсхүл бүртгүүлэлгүйгээр мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ үзүүлж буй этгээдэд зохих захиргааны, иргэний, болон эрүүгийн хариуцлага ногдуулна.¹¹ Лицензтэй эсхүл бүртгэлтэй мөнгө болон үнэт зүйлс шилжүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь ФАТФ Дөчин зөвлөмж болон Найман Тусгай зөвлөмжийн холбогдох заалтыг дагаж мөрдөөгүй бол түүнд нь тохирсон хариуцлагын арга хэмжээг ногдуулна.

¹¹ Улс орнууд энэхүү Тусгай зөвлөмжийг хэрэгжүүлэх үед түүнээс өмнө байгуулагдсан мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө шилжүүлгийн үйлчилгээнд лиценз авах болон бүртгүүлэх боломж олгохын тулд түр зуур үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгож болно.

ТАЙЛБАР

ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ VII: ЦАХИМ ШИЛЖҮҮЛЭГ¹² ШИНЭЧИЛСЭН¹³

Зорилго

1. Тусгай зөвлөмж VII (ТЗ VII) нь террорист болон бусад гэмт хэрэгтэнийг мөнгө, хөрөнгөө шилжүүлэхийн тулд цахим шилжүүлгийг ямар ч саадгүй ашиглахаас урьдчилан сэргийлэх, ийнхүү буруугаар ашиглах явдал гарсан тохиолдолд түүнийг илрүүлэх зорилгоор гаргасан. Ялангуяа, энэ нь цахим шилжүүлэг хийж буй харилцагчийн үндсэн мэдээлэл: (1) холбогдох хууль хяналтын байгууллага болон шүүхийн байгууллагад террорист болон бусад гэмт хэрэгтэнийг илрүүлэх, мөрдөн шалгах, шүүх, мөн тэдгээрийн хөрөнгийг олж илрүүлэхэд туслах, (2) санхүүгийн мэдээллийн албанд сэжигтэй болон хэвийн бус үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх болон шаардлагатай тохиолдолд мэдээллийг цааш нь дамжуулахад, (3) хүлээн авагч санхүүгийн байгууллагад сэжигтэй гүйлгээг таних, мэдээлэхэд туслах зорилгоор дээрх байгууллагууд ашиглахад бэлэн байх боломжийг хангахад чиглэгдэх шаардлагатай. Бага хэмжээний цахим шилжүүлэг ч терроризмыг санхүүжүүлэх бодит эрсдэлтэй байж болохыг харгалзан, улс орнууд бүх цахим шилжүүлгийн мэдээллийг авах, мэдээлэх тогтоосон хэмжээг бууруулах гэхдээ энэ нь хууль бусаар шилжүүлэг хийх эрсдлийг нэмэгдүүлж болзошгүйг тооцон цаашид энэ чигийг барьж ажиллана. ФАТФ төлбөр тооцооны системд сөргөөр нөлөөлөхөөр уян хатан бус стандарт тогтоох, эсхүл нэг үйлдлийн системтэй байхыг шаардахыг зориогүй болно. ФАТФ нь Тусгай зөвлөмж VII-ын үр нөлөөг үргэлжлүүлэн хянах бөгөөд бүрэн хэрэгжүүлж эхэлснээс хойш гурван жилийн дараа үйл ажиллагааны үнэлгээ хийх болно.

Тодорхойлолт

2. Энэхүү Тайлбарт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
- a. *Цахим шилжүүлэг* болон *мөнгөн шилжүүлэг* гэж гуйвуулагчийн (хувь хүн, хуулийн этгээд аль аль нь) нэрийн өмнөөс санхүүгийн байгууллагаар дамжуулан цахим хэлбэрээр хийж, хүлээн авагч мөнгийг өөр санхүүгийн байгууллагаас хүлээн авах нөхцөлтэйгээр хийгдэж буй гүйлгээг хэлнэ. Гуйвуулагч болон хүлээн авагч нь нэг хүн байж болно.
 - b. *Хил дамнасан шилжүүлэг* гэж өөр өөр улс, бүс нутагт байрлах гуйвуулагч болон хүлээн авагч байгууллагаар хийгдэх цахим шилжүүлгийг хэлнэ. Энэхүү нэр томъёо нь мөн дор хаяж нэг хил дамнасан бүрэлдэхүүн орсон цахим шилжүүлгийн сүлжээг хэлнэ.

¹² Улс орнуудад холбогдох хууль эрх зүйн болон хяналт шалгалтын өөрчлөлт хийх, мөн санхүүгийн байгууллагад өөрийн систем, үйл ажиллагаанд шаардлагатай тохиргоо, өөрчлөлтийг хийх боломж олгоход тодорхой цаг хугацаа хэрэгтэй байдаг нь тогтоогдсон. Уг хугацаа нь 2006 оны 12 сараас хэтрэхгүй байна.

¹³ Энэ шинэчилсэн хувилбар 2008 оны 2-р сарын 29-нд гарсан.

- с. *Дотоод шилжүүлэг* гэж нэг улсад байршилтай гуйвуулагч болон хүлээн авагч байгууллагаар хийгдэх цахим шилжүүлгийг хэлнэ. Тиймээс, хэдийгээр цахим шилжүүлгийг гүйцэтгэдэг систем нь өөр улсад байрлаж болох ч, уг нэр томъёо нь нэг улсын хил дотор хийгдэх цахим шилжүүлгийн сүлжээг хэлнэ. Энд мөн Европын холбооны хил дотор хийгдсэн цахим шилжүүлгийг хамруулан ойлгоно¹⁴.
- d. *Санхүүгийн байгууллага* гэж ФАТФ-ын Дөчин зөвлөмж (2003)-д тодорхойлсон байгууллагыг хэлнэ.¹⁵ Энэхүү нэр томъёо нь мөнгө, хөрөнгийн шилжүүлэг хийхэд санхүүгийн байгууллагыг дан ганц мэдээллээр хангадаг хувь хүн, хуулийн этгээд эсхүл мөнгө шилжүүлэх бусад туслах системд¹⁶ хамаарахгүй.
- e. *Гуйвуулагч* гэж данс эзэмшигч эсхүл данс эзэмшдэггүй санхүүгийн байгууллагад цахим шилжүүлэг гүйцэтгүүлэхээр хандаж буй этгээд (хувь хүн эсхүл хуулийн этгээд)-ийг хэлнэ.

Хамрах хүрээ

3. ТЗ VII нь дор дурьдсан нөхцлийн дагуу санхүүгийн байгууллагын хооронд хийгдэх хил дамнасан болон дотоод шилжүүлгийг хамарна.

Хил дамнасан цахим шилжүүлэг

4. Хил дамнасан цахим шилжүүлэг нь гуйвуулагчийн талаарх үнэн зөв, ач холбогдолтой мэдээллийг агуулсан байх шаардлагатай. Улс орнууд доод зааг (1,000 ам.доллар буюу еврогоос ихгүй) тогтоож болно. Энэ заагаас доош хил дамнасан цахим шилжүүлэг хийх үед:

- a. Улс орнууд шилжүүлэг хийж байгаа санхүүгийн байгууллагаас гуйвуулагчийг таних, мэдээллийг шалгах болон гуйвуулагчийн тухай мэдээллийг шилжүүлэхийг шаардах шаардлагагүй.

¹⁴ Дараахь зүйлсийг анхаарах хэрэгтэй:

Европын холбоо (ЕХ) нь бие даасан этгээд бөгөөд өөрийн эрхтэй, ЕХ бүрэн эрхэд хамаарах хүрээний асуудлаар гишүүн улс болон иргэдэд хамааралтай хуулийн шийдвэрийг гишүүн орнуудаас хамааралгүй гаргадаг .

ЕХ нь гишүүн улсууд даган мөрдөх шаардлагатай хууль гаргасан бөгөөд энэ нь гишүүн орнуудын хооронд капитал, бараа таваар, үйлчилгээг чөлөөтэй нэвтрүүлэх зарчмын дагуу дотоодын зах зээл дээрх төлбөр тооцооны үйлчилгээний нэгдмэл байдлыг хангаж байдаг. Энэ хуулинд ТЗ VII-г нэг улс шиг хэрэгжүүлэх шаардлагатай гэж тусгасан бөгөөд гуйвуулагчийн тухай бүрэн мэдээллийг хүлээн авагч талын санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллагаас зохих хүсэлт тавьсан үед гарган өгөх бололцоотой байх шаардлага тусгасан. Европын дотоод зах зээл болон хууль, эрх зүйн орчин мөн Европын эдийн засгийн бүсэд хамаарна гэж тусгасан.

¹⁵ Энэхүү Тайлбарыг анх 1996 оны ФАТФ-ын Дөчин зөвлөмжид зориулан гаргасан. ФАТФ-ын Дөчин зөвлөмжийн дараагийн шинэчлэгдсэн хэвлэлт 2003 оны 6 дугаар сард гарах үед уг Тайлбар мөн шинэчлэгдсэн. Одоогийн Тайлбар нь 2003 оны ФАТФ-ын Дөчин зөвлөмжид хамааралтай болно.

¹⁶ Хэдий тийм боловч, эдгээр систем нь ТЗ VII-оор хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор цахим шилжүүлэгтэй хамт шилжүүлсэн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хадгалах замаар санхүүгийн байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангахад тодорхой хэмжээгээр үүрэг гүйцэтгэдэг.

- b. Улс орнууд гаднаас ирж байгаа хил дамнасан цахим шилжүүлэгт гуйвуулагчийн тухай бүрэн, үнэн зөв мэдээллийг агуулсан байх шаардлага тавьж болно.

5. Хил дамнасан цахим шилжүүлгийг дагалдах мэдээлэл¹⁷ нь гуйвуулагчийн овог нэр, дансны дугаар, данс хаана байршдаг талаарх мэдээллийг агуулсан байх ёстой. Данс байхгүй тохиолдолд тусгай тодорхойлсон дугаар заавал байх шаардлагатай.

6. Цахим шилжүүлгийг дагалдах мэдээлэл нь гуйвуулагчийн хаягийг мөн агуулсан байх шаардлагатай. Гэхдээ, улс орнууд хаягийг үндэсний хэмжээний тодорхойлох дугаар, харилцагчийн дугаар, эсхүл төрсөн огноогоор орлуулахыг санхүүгийн байгууллагад зөвшөөрч болно.

7. Нэг гуйвуулагчийн хэд хэдэн шилжүүлгийг багцлан файл болгон өөр улсад байгаа хүлээн авагчид шилжүүлж байгаа бол гуйвуулагчийн дансны дугаар болон үндэсний хэмжээний тодорхойлох дугаар зэрэг мэдээллийг (8-р зүйлд тусгасан) агуулсан бүрэн мэдээллийг явуулахгүй байж болно. Багцалсан файлын мэдээлэлд хүлээн авагч тал гуйвуулагчийг тодорхойлох бүрэн мэдээлэл агуулах шаардлагатай.

Дотоод цахим шилжүүлэг

8. Хэрэв хүлээн авагч санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллага гуйвуулагчийн талаарх бүрэн мэдээллийг өөр арга, замаар авдаггүй л бол, дотоод цахим шилжүүлгийг дагалдах мэдээлэл нь гуйвуулагчийн талаарх мэдээллийг агуулсан байх ёстой. Мэдээллийг өөр арга, замаар авдаг тохиолдолд, санхүүгийн байгууллага зөвхөн өгөгдсөн дансны дугаар эсхүл тусгай таних дугаарыг оруулах бөгөөд уг дугаар болон таних дугаар нь гүйлгээг шалгах явцад гуйвуулагчийн талаарх мэдээллийг олох боломж олгоно.

9. Энэ мэдээллийг шилжүүлэгч санхүүгийн байгууллага мэдээллийг хүлээн авагч санхүүгийн байгууллага болон эрх бүхий байгууллагаас хүсэлт ирснээс хойш ажлын гурав хоногийн дотор гаргаж өгнө. Хууль, хяналтын байгууллага ийм мэдээллийг шууд гаргуулан авах эрхтэй байх шаардлагатай.

ТЗ VII-д хамрагдахгүй тохиолдол

10. ТЗ VII нь доорх төрлийн төлбөрүүдийг хамруулахгүй болно. Үүнд:

- a. Кредит болон дебит карт ашиглан хийгдэх гүйлгээгээр дамжин хийгдэх бүх шилжүүлэгт кредит болон дебит картны дугаар дагалддаг бол тэдгээр бүх шилжүүлэг. Гэхдээ, кредит болон дебит карт нь мөнгөн шилжүүлгийг гүйцэтгэх төлбөр тооцооны хэрэгслээр ашиглагдаж байгаа бол ТЗ VII-д хамрагдах бөгөөд шаардлагатай бүх мэдээлэл дагалдан явах шаардлагатай.

¹⁷“ Хамаарах хил дамнасан цахим шилжүүлгийг дагалдах мэдээлэл” гэж 4-р зүйлд тогтоосон заагнаас давсан хил дамнасан цахим шилжүүлэг

- б. Санхүүгийн байгууллагаас-санхүүгийн байгууллага руу хийх шилжүүлэг болон санхүүгийн байгууллагууд өөрийн нэрийн өмнөөс гуйвуулагч болон хүлээн авагчийн үүрэг гүйцэтгэн хийх шилжүүлэг, төлбөр тооцоо.

Шилжүүлэгч, зуучлагч болон хүлээн авагч санхүүгийн байгууллагын үүрэг

Шилжүүлэгч санхүүгийн байгууллага

11. Шилжүүлэгч санхүүгийн байгууллага нь хамаарах цахим шилжүүлэг гуйвуулагчийн талаарх бүрэн мэдээллийг агуулсан байх шаардлагыг биелүүлнэ. Түүнчлэн, шилжүүлэгч санхүүгийн байгууллага ФАТФ Дөчин зөвлөмж (2003)¹⁸-д заасан стандартын дагуу мэдээллийг шалгах, түүнийг хадгалах шаардлагатай.

Зуучлагч санхүүгийн байгууллага

12. Хил дамнасан болон дотоод цахим шилжүүлэг хоёрын хувьд, тухайн цахим шилжүүлгийн сүлжээнд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж буй санхүүгийн байгууллага цахим шилжүүлгийг дагалдах гуйвуулагчийн мэдээлэл нь тухайн шилжүүлэгтэй хамт шилжигдэж байх шаардлагыг биелүүлнэ.

13. Хил дамнасан цахим шилжүүлгийг дагалдах гуйвуулагчийн бүрэн мэдээлэл техникийн хязгаарлалтаас болоод холбогдох дотоод цахим шилжүүлэгтэй хамт шилжигдэхгүй тохиолдолд (төлбөр тооцооны систем шинэчлэгдэх хүртэл) хүлээн авсан зуучлагч санхүүгийн байгууллага нь гуйвуулагч санхүүгийн байгууллагаас хүлээн авсан бүх мэдээллийг таван жилийн хугацаатай хадгална.

Хүлээн авагч санхүүгийн байгууллага

14. Хүлээн авагч санхүүгийн байгууллага гуйвуулагчийн мэдээлэл нь бүрэн бус цахим шилжүүлгийг таних үр дүнтэй, эрсдлийг тооцсон арга хэмжээ авдаг байх шаардлагатай. Гуйвуулагчийн бүрэн бус мэдээлэл нь цахим шилжүүлэг буюу холбогдох гүйлгээг сэжигтэй эсэх, мөн тэдгээрийг Санхүүгийн мэдээллийн алба эсхүл бусад эрх бүхий байгууллагад мэдээлэх эсэхийг тодорхойлох үзүүлэлтэд тооцогдож болно. Зарим тохиолдолд, хүлээн авагч санхүүгийн байгууллага ТЗ VII-ийн стандартыг дагаж мөрдөөгүй санхүүгийн байгууллагатай хийх бизнес харилцаандаа хязгаарлалт хийх, эсхүл бүр харилцаагаа таслах хүртэл арга хэмжээ авч болно.

Цахим шилжүүлэгтэй холбоотой дүрэм, журмыг биелүүлээгүй санхүүгийн байгууллагад авч хэрэгжүүлэх албадлагын арга хэмжээ

15. Улс орнууд санхүүгийн байгууллагын цахим шилжүүлэгтэй холбоотой дүрэм, журмын хэрэгжилтийг хянах үр дүнтэй, тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Дүрэм, журмыг биелүүлээгүй санхүүгийн байгууллагад иргэний, захиргааны болон эрүүгийн хариуцлага ногдуулдаг байх шаардлагатай.

¹⁸ 15-ийг үз

ТАЙЛБАР
ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ VIII: АШГИЙН БУС БАЙГУУЛЛАГА

Удиртгал

1. Ашгийн бус байгууллага (АББ) нь дэлхийн эдийн засаг болон олон орны эдийн засаг, нийгэмд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр байгууллагууд дэлхий даяар тусламж хэрэгтэй байгаа хүмүүст наад захын хэрэгцээгээ хангахад туслалцаа, дэмжлэг үзүүлэх, итгэл өгөх талаар засгийн газар болон хувийн хэвшлийн хэрэгжүүлдэг үйл ажиллагааг дэмжин үйл ажиллагаа явуулдаг. Харамсалтай нь террористууд болон террорист байгууллага хөрөнгө цуглуулах болон шилжүүлэх, логистикийн дэмжлэг үзүүлэх, террорист этгээдийг эгнээндээ элсүүлэхэд болон террорист байгууллага, үйл ажиллагааг дэмжихэд АББ-ыг ашиглаж байгааг терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг хийж байгаа олон улсын тэмцэл харуулж байна. Энэ хууль бус үйлдэл нь террорист үйл ажиллагааг дэмжээд зогсохгүй хандивлагчдын итгэлийг алдуулах, АББ-ын үндэс суурийг ганхуулахад хүргэж байна. Иймээс АББ-ын салбарыг террорист үйл ажиллагаанаас сэргийлэх нь дэлхий даяар терроризмын эсрэг тэмцэх маш чухал алхам болох төдийгүй АББ-ын үндэс суурийг хамгаалан авч үлдэхэд шаардлагатай алхам болох юм.

2. АББ нь олон төрлийн шалтгааны улмаас террористуудад хууль бусаар ашиглагдах эрсдэлтэй байна. АББ нь үлэмж хэмжээний хөрөнгийн эх үүсвэртэй, бэлэн мөнгөтэй их харилцдаг бөгөөд олон нийтийн итгэл хүлээсэн байгууллага байдаг. Түүнчлэн зарим АББ нь террорист үйл ажиллагаа идэвхтэй явагддаг газар нутагт болон тэдгээрийн ойролцоох бүс нутагт үндэсний болон олон улсын хэмжээний үйл ажиллагаа явуулах, санхүүгийн гүйлгээ хийх гэх зэрэг олон улсын шинжтэй үйл ажиллагаа явуулж байна. Тухайн улс орон болон АББ-ын төрлөөс хамаарч ихэвчлэн төрийн байгууллагаас АББ-ыг хянах тогтолцоо маш сул буюу огт байхгүй (тухайлбал, бүртгэх, мэдээлэл хадгалах, мэдээлэх болон хяналт тавих асуудал дээр), мөн тэдгээрийг үүсгэн байгуулахад маш бага шалгуур тавих буюу хэдхэн заавар журам мөрдөхийг шаарддаг (тухайлбал, үүсгэн байгуулах хөрөнгө, ур чадвар шаарддаггүй, ажилтнуудын мэдээллийг шалгах шаардлага тавьдаггүй гэх мэт) байх нь бий. Террорист байгууллагууд АББ-ын эдгээр сул талыг ашиглан террорист үйл ажиллагаагаа дэмжих, нуун далдлах зорилгоор уг салбарт нэвтрэх, улмаар АББ-ын хөрөнгө болон үйл ажиллагааг хууль бусаар ашигладаг байна.

Зорилго болон Ерөнхий зарчим

3. Тусгай зөвлөмж VIII (ТЗ VIII)-ын зорилго бол АББ-ыг террорист байгууллагуудын хууль бус үйл ажиллагаанд ашиглуулахгүй байх арга хэмжээ авах явдал юм. Үүнд: (i) хууль ёсны байгууллагын нэрэн дор террорист байгууллага нуугдах; (ii) терроризмыг санхүүжүүлэх болон хөрөнгө, мөнгийг хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авахаас зайлсхийх зорилгоор ашиглах; (iii) хууль ёсны үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгө, мөнгийг зохион байгуулалттай террорист байгууллагын үйл ажиллагаанд зориулахаар гуйвуулах, нуун далдлах. Энэ Тайлбарт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх чиг хандлага нь дараахь ерөнхий зарчим дээр суурилсан болно. Үүнд:

- a. АББ-ын салбарыг террорист болон террорист байгууллага хууль бусаар ашиглаж байгаа болон ашиглаж байсан явдал нь улс орнуудыг: (i) энэ салбарыг хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах; (ii) террорист болон террорист байгууллагад ашиглагдаж байгаа болон тэднийг идэвхтэй дэмждэг АББ-ыг тодорхойлох, эдгээр байгууллагын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахыг шаардаж байна.
- b. АББ-ыг хууль бус, террорист үйл ажиллагаанаас хамгаалах арга хэмжээ нь албан ёсны хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах ёсгүй. Чухамдаа эдгээр арга хэмжээ нь хандивлагчид болон олон нийтийн дунд хандивын хөрөнгө болон буяны үйлчилгээ нь очих ёстой хууль ёсны хүлээн авагчид хүрч чадаж байгаа гэсэн итгэлийг төрүүлдэг, ил тод байдлыг бэхжүүлдэг байх шаардлагатай. АББ-ын удирдлага болон үйл ажиллагааны ил тод байдал, шударга ёс болон олон нийтийн итгэлийг хөхүүлэн дэмждэг тогтолцоо нь энэ салбарыг терроризмыг санхүүжүүлэхэд хууль бусаар ашиглагдахаас найдвартай сэргийлэх нэг үндэс юм.
- c. Улс орнуудын террорист байгууллагад ашиглагдаж байгаа болон идэвхтэй дэмждэг АББ-ыг тодорхойлох, тэдний эсрэг авах үр дүнтэй арга хэмжээ нь терроризмыг санхүүжүүлэх, бусад төрлийн терроризмоос урьдчилан сэргийлэх болон мөрдөн шалгах зорилготой. Хэрвээ АББ нь терроризмыг санхүүжүүлэх болон бусад төрлийн терроризмыг дэмжих үйл ажиллагаатай холбоотой буюу тийм сэжиг байвал юуны түрүүнд тухайн улс энэ талаар мөрдөн байцаалт явуулан терроризмыг санхүүжүүлэх болон дэмжих үйл ажиллагааг таслан зогсоох шаардлагатай. Энэ арга хэмжээ нь гэм буруугүй, хууль ёсны хандивыг хүлээн авагчид дарамт учруулахгүй байх шаардлагатай. Гэхдээ энэ нь АББ-ын терроризмыг санхүүжүүлэх болон дэмжих үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг цаг алдалгүйг авх, үр дүнтэй хэрэгжүүлэхгүй байх шалтгаан болох ёсгүй.
- d. Олон нийт, хувийн болон АББ-ын салбар хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь энэ салбарыг террористууд ашиглахаас сэргийлэх, мэдлэг, мэдээллийг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой. Улс орнууд АББ-ын салбар дахь терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой асуудлаар судалгаа хийх болон мэдээлэл солилцох үйл ажиллагааг хөгжүүлэхийг дэмжих шаардлагатай.
- e. Үндэстэн болгоны АББ-ын салбарын хөгжлийн ялгаатай байдал, террористуудад хууль бусаар ашиглагдах боломжтой салбарын өртөмтгий хэсэг янз бүр байх, хууль ёсны хүмүүнлэгийн үйл ажиллагааг тасалдуулахгүй байх, улс орон бүрийн терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх байгууллага болон үүнд ашиглах бололцоотой хязгаарлагдмал нөөц зэрэг онцлогийг харгалзан АББ-ын салбарын терроризмд өртөх магадлалыг тооцон, тодорхой чиглэсэн арга хэмжээ авах нь маш чухал.
- f. АББ-ын салбарт терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний арга хэмжээ хэрэгжүүлэхэд уян хатан байх нь ирээдүйд терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны хувиралтад тохирсон хариу барихад онцгой ач холбогдолтой.

Тодорхойлолт

4. ТЗVIII болон энэ Тайлбарт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- a. *Ашигийн бус байгууллага буюу АББ* нь хүмүүнлэгийн, шашны, соёл урлагийн, боловсролын, олон нийтийн болон ахан дүүсийн, болон бусад төрлийн сайн санааны үйл ажиллагаа эрхлэх зорилгоор хөрөнгө цуглуулах, тараах үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд буюу байгууллагыг хэлнэ;
- b. *СМА, хуулийн этгээд болон байгууллага* гэж ФАТФ-ын Дөчин зөвлөмжид (2003) тодорхойлсныг тус тус хэлнэ;
- c. *Хөрөнгө* гэж ФАТФ-ын Тусгай зөвлөмж II-ын Тайлбарт тодорхойлсныг хэлнэ;
- d. *Хөдөлгөөнгүй болгох, террорист болон террорист байгууллага* гэж ФАТФ-ын Тусгай зөвлөмж III-ын Тайлбарт тодорхойлсныг тус тус хэлнэ;
- e. *Зохих байгууллага* гэж эрх бүхий байгууллага, өөрийгөө зохицуулдаг байгууллага, итгэмжлэгдсэн байгууллага болон бусад захиргааны байгууллагыг хэлнэ;
- f. *Хүлээн авагч* гэж хувь буяны, хүмүүнлэгийн болон бусад төрлийн тусламж, дэмжлэгийг АББ-ын үйл ажиллагаагаар дамжуулан хүлээн авч байгаа хүн, хэсэг бүлэг хувь хүмүүсийг хэлнэ.

Арга хэмжээ

5. Улс орнууд АББ-ын салбарт дотоод үнэлгээ хийдэг, мөн уг салбарын үйл ажиллагаа, хэмжээ болон бусад холбогдох хүчин зүйлсийн талаарх мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол авах хүчин чадал, боломжтой байх шаардлагатай. Ийм үнэлгээ хийхдээ улс орнууд байгаа бүх мэдээллийг өргөн хүрээнд ашиглах нь АББ-ууд төрөл болон үйл ажиллагаанаас хамаарч ямар төрлийн эрсдэл байгааг болон юу нь терроризмыг санхүүжүүлэхэд хууль бусаар ашиглагдах эрсдэлтэй байгааг тогтооход ашиглана¹⁹. Улс орнууд энэ салбарт шинээр гарч байгаа терроризмтой холбоотой эрсдэлийн мэдээллийг тогтмол шинэчилж, дахин үнэлгээ хийж байх шаардлагатай.

6. АББ-ыг террористууд хууль бусаар ашиглаж байгааг тодорхойлох, сэргийлэх болон тэмцэх олон төрлийн арга хэлбэр байдаг. Гэхдээ хамгийн оновчтой нь дараахь дөрвөн зүйлийг агуулсан байх явдал юм. Үүнд: (а) тухайн салбарт соён гэгээрүүлэх сурталчлах үйл ажиллагаа явуулах; (б) хяналт шалгалттай байх; (в) мэдээлэл цуглуулах болон мөрдөн байцаалтыг үр дүнтэй явуулах; (г) олон улстай хамтын ажиллагааг үр өгөөжтэй явуулах орно. АББ-ын салбарыг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглагдахаас сэргийлж дээрх зүйлүүдтэй уялдуулан дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

a. АББ-ын салбарт терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг таниулах

(i) Улс орнууд АББ-ын удирдлага болон үйл ажиллагааны ил тод, шударга байдал болон итгэлийг олон нийтийн дунд нэмэгдүүлэх тодорхой бодлоготой байх шаардлагатай.

¹⁹ Жишээ нь, энэ төрлийн мэдээллийг зохицуулах байгууллага, татварын байгууллага, СМА, хандивлагч байгууллага, хууль хяналтын байгууллага болон тагнуулын байгууллагаас авч болно.

(ii) Улс орнууд АББ-ын салбарт террористуудад хууль бусаар ашиглагдах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, түүнээс сэргийлэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай соён гэгээрүүлэх, сурталчлах үйл ажиллагааг дэмжих, явуулах шаардлагатай.

(iii) Улс орнууд АББ-ын салбарын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах талаар авах зохистой арга хэмжээг тодорхойлох, улам сайжруулах болон энэ салбарыг хамгаалах талаар хамтран ажиллах шаардлагатай²⁰.

(iv) Улс орнууд АББ-ыг улс орнуудын болон бүс нутгуудын санхүүгийн салбарын чадавх янз бүр байх, буяны болон хүмүүнлэгийн үйл ажиллагаанд бий болсон яаралтай нөхцөл байдал зэргийг харгалзан үзэж, албан ёсны санхүүгийн салбарыг боломжтой тохиолдолд ашиглан төлбөр тооцоо гүйцэтгэхийг дэмжих шаардлагатай.

б. АББ-ын салбарын хяналт шалгалт

Улс орнууд АББ-ын салбарыг үр дүнтэй хяналт шалгалтанд хамруулах талаар арга хэмжээ авах шаардлагатай. Гол нь (1) салбарын хянаж байдаг санхүүгийн эх үүсвэрийн ихэнхийг эзэлдэг; болон (2) салбарын гадаад үйл ажиллагааны ихэнхийг эзэлдэг АББ-д дараахь стандартууд мөрдөгдөж байгааг нотлох шаардлагатай.

(i) АББ-ууд дараахь мэдээллийг хадгалах үүрэгтэй: (1) Товлосон үйл ажиллагаа, түүний зорилго болон чиглэл, (2) Хувь эзэмшигч, үйл ажиллагааг хянадаг болон удирддаг удирдах түвшний албан тушаалтан, удирдах зөвлөлийн гишүүн болон итгэмжлэгдсэн хүний биеийн байцаалт. Энэ мэдээлэл нь олон нийтэд ил байх буюу холбогдох байгууллагаар дамжуулан авах бололцоотой байх шаардлагатай.

(ii) АББ-ууд жил бүр орлого, зарлагын санхүүгийн тайлан гаргаж байх шаардлагатай.

(iii) АББ бүртгүүлсэн буюу тусгай зөвшөөрөл авсан байх шаардлагатай. Энэ мэдээлэл эрх бүхий байгууллагад нээлттэй байх шаардлагатай.²¹

(iv) АББ-ын бүх хөрөнгө бүртгэл, тооцоонд хамрагдсан, товлосон үйл ажиллагаа, түүний зорилгод нийцсэн чиглэлд зарцуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих арга хэрэгсэлтэй байх шаардлагатай.

(v) АББ нь “хүлээн авагч болон АББ-ын хамтрагч түншээ таних”²² зарчмыг мөрдөх шаардлагатай. Энэ нь АББ-ын хүлээн авагч болон хамтрагч түншийн биеийн байцаалт, итгэмжлэл болон нэр хүндийг тодорхойлох, батлах бүх л бололцоотой арга хэмжээг авна. АББ нь гол томоохон хандивлагчийн хэн болохыг нотлох баримтыг цуглуулах болон түүний нууцыг хадгалах үүрэгтэй.

²⁰ ФАТФ-ын *Ашигийн бус байгууллагыг хууль бусаар ашиглахтай тэмцэх олон улсын туршилага* гарын авлагыг жишиг болгон ашиглаж болно.

²¹ Зөвхөн терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой тусгай бүртгэл буюу тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагагүй. Жишээ нь: Зарим улсад АББ нь татварын албанд бүртгэлтэй бөгөөд татварын хөнгөлөлт (татварын хөнгөлөлт болон чөлөөлөлт) эдлэхийн тулд хяналттай байдаг.

²² АББ-ын хамтрагч түншид олон улсын АББ-ын гадаадын салбар хамаарна.

(vi) АББ нь гадаад, дотоод гүйлгээний талаарх мэдээллийг таваас доошгүй жил хадгалах бөгөөд шаардлагатай үед холбогдох байгууллагад гаргаж өгнө. Энэ мэдээлэл нь хөрөнгө мөнгийг байгууллагын үйл ажиллагаа, зорилго, чиглэлд хэрхэн нийцүүлэн зарцуулсан тухай хангалттай дэлгэрэнгүй, шалгах бололцоотой мэдээллийг агуулна. Энэ заалт (i) болон (ii) зүйлд тусгасан мэдээлэлд мөн хамаарна.

(vii) Холбогдох байгууллага АББ-ыг журам, дүрмийг хэрхэн биелүүлж байгаа талаар хяналт тавина.²³ Холбогдох байгууллага нь АББ-ын гаргасан зөрчил болон тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа этгээдэд тохирсон арга хэмжээ авах арга хэрэгсэлтэй байх шаардлагатай.²⁴

в. Мэдээлэл цуглуулах болон мөрдөн байцаалтыг үр дүнтэй явуулах

(i) Улс орнууд АББ-ын талаар мэдээлэл бүхий холбогдох байгууллага, газруудын үйл ажиллагааг уялдуулах, хамтран ажиллах болон мэдээллийг солилцох талаар үр дүнтэй арга хэмжээ авах шаардлагатай.

(ii) Улс орнууд террорист байгууллага болон террорист үйл ажиллагааг идэвхтэй дэмждэг, сэжиглэгдэж байгаа болон ашиглагдаж байгаа АББ-ын талаар мөрдөн шалгах болон дүн шинжилгээ хийх арга хэрэгсэлтэй байх шаардлагатай.

(iii) Улс орнууд мөрдөн байцаалтын явцад тухайн АББ-ын үйл ажиллагаа болон удирдлагын (санхүүгийн болон төлөвлөгөөний мэдээлэл хамаарна) талаар бүрэн мэдээлэл авах бололцоотой байх талаар шаардлагатай арга хэмжээ авна.

(iv) Улс орнууд хэрвээ АББ нь (1) террорист байгууллагын хөрөнгө цуглуулах үйл ажиллагааны халхавч болсон; (2) терроризмыг санхүүжүүлэх болон хөрөнгө, мөнгийг хөдөлгөөнгүй болгох арга хэмжээ авахаас зайлсхийсэн; болон (3) хууль ёсны үйл ажиллагаанд зориулагдсан хөрөнгө, мөнгийг зохион байгуулалттай террорист байгууллагын үйл ажиллагаанд зориулахаар гуйвуулсан буюу нуун далдалсан бол, эсхүл тэгж үзэх хангалттай үндэслэл байгаа бол мэдээллийг холбогдох байгууллагуудтай цаг алдалгүй солилцож, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

г. АББ-ын талаар гадаадаас ирсэн мэдээллийн хүсэлтэд хариулах үр өгөөжтэй тогтолцоотой байх

Улс орнууд Тусгай зөвлөмж V-ийн дагуу терроризмыг санхүүжүүлэх болон бусад хэлбэрээр терроризмыг дэмждэг үйл ажиллагаанд сэжиглэгдэж байгаа АББ-ын талаар гадаадаас ирсэн мэдээллийн хүсэлтийг хүлээн авах, хариулах арга зам, журмыг тогтоосон байна.

²³ Энд журам, дүрэмд мөн өөрийгөө зохицуулдаг байгууллага, итгэмжлэгдсэн байгууллагын хэрэгжүүлдэг журам, стандарт мөн хамаарна.

²⁴ Авч болох арга хэмжээнд гүйлгээг хөдөлгөөнгүй болгох, итгэмжлэлийг хүчингүй болгох, торгох, дахин баталгаажуулах, дахин бүртгэлд оруулах, лицензийг хураан авах байж болно. Энэ нь иргэний захиргааны болон эрүүгийн журмаар давхар хариуцлага хүлээлгэхээр хэрэг үүсгэхэд саад болох ёсгүй.

ТАЙЛБАР

ТУСГАЙ ЗӨВЛӨМЖ IX: БЭЛЭН МӨНГӨ ТЭЭВЭРЛЭГЧ

Зорилго

1. FATF Тусгай Зөвлөмж IX-ийг террорист болон гэмт хэрэгтэн мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр бэлнээр нэвтрүүлэх замаар өөрсдийн гэмт үйл ажиллагааг санхүүжүүлэх, эсхүл гэмт хэргээс олсон орлогоо угаах үйл явцыг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан. Бүр тодруулбал, энэхүү зөвлөмж нь улс орнуудыг дараах арга хэрэгсэлийг бий болгохыг зөвлөсөн байна. Үүнд:

1) мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр бэлнээр нэвтрүүлж байгааг илрүүлэх,

2) мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор тээвэрлэж байна гэж үзвэл түүнийг зогсоох болон саатуулах арга хэмжээ авах,

3) мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг худал мэдүүлсэн бол түүнийг зогсоох болон саатуулах арга хэмжээ авах,

4) худал мэдүүлсэн үйлдэлд тохирсон хариуцлагын арга хэмжээ авах,

5) терроризмыг санхүүжүүлэх эсхүл мөнгө угаахтай холбоотойгоор тээвэрлэж буй мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хураан авах. Улс орнууд Тусгай Зөвлөмж IX-ийн мэдээллийг зөв зохистой ашиглан, i) улс орнуудын хооронд хийгдэх худалдаа, үйлчилгээний төлбөр тооцоо болон ii) хөрөнгийн чөлөөт урсгалд хязгаарлалт хийлгүйгээр хэрэгжүүлнэ.

Тодорхойлолт

2. Тусгай Зөвлөмж IX болон энэхүү Тайлбарт хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3. *үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэл* гэж замын чек зэрэг үзүүлэгчид шилжих мөнгөн төлбөр тооцооны хэрэгсэл; нэр нь тодорхойгүй төлбөр хүлээн авагчид ямар нэг нөхцөл заалгүйгээр, эсхүл төлбөрийн хэрэгсэлийг хүлээн авсаны дараа эрх нь шилжих нөхцөлтэй гаргасан үзүүлэгчид шилжих төлбөрийн хэрэгсэл (чек, өрийн бичиг, төлбөрийн даалгавар гэх мэт); гарын үсэг зурагдсан боловч төлбөр хүлээн авагчийн нэр байхгүй бүрдэл дутуу төлбөрийн хэрэгсэл (чек, өрийн бичиг, төлбөрийн даалгавар гэх мэт) зэрэг хэлцлийн бусад хэрэгсэлүүдийг хэлнэ.²⁵

²⁵ Алт, үнэт металл болон үнэт чулуу нь хэдийгээр хөрвөх чадвар өндөртэй бөгөөд зарим тохиолдолд солилцооны болон шилжүүлгийн хэрэгсэлээр ашиглагддаг боловч энэхүү Тайлбарын дээрх тодорхойлолтонд ороогүй болно. Эдгээр нь гаалийн хууль, журмаар зохицуулагддаг байж болно. Хэрэв улс орон алт, үнэт металл, эсхүл үнэт чулууг хил нэвтрүүлэх сэжиг бүхий үйлдлийг илрүүлсэн бол уг эд зүйлс орж ирсэн улсын эсхүл нэвтэрч орох улсын гаалийн байгууллага юмуу

4. *мөнгөн тэмдэгт* гэж эргэлтэнд байгаа төлбөр тооцооны хэрэгсэл болох цаасан мөнгө болон зоосыг хэлнэ.

5. *хилээр бэлнээр нэвтрүүлэх* гэж нэг улсаас нөгөө улс руу мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг бэлнээр хилээр оруулж, гаргахыг хэлнэ. Энэхүү нэр томъёо нь дараах төрлийн тээвэрлэлтүүдийг хамарна: (1) хувь хүн болон түүнийг дагалдан яваа ачаа, тээврийн хэрэгсэлээр дамжуулах; (2) мөнгөн тэмдэгтийг чингэлэгээр зөөх; (3) хувь хүн, хуулийн этгээд мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг шуудангаар илгээх.

6. *декларацид худал мэдүүлэх* гэж авч явж буй мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийн дүнг буруу мэдүүлэх, эсхүл декларацийн мэдүүлэг юмуу эрх бүхий албан байгууллагын асуултанд холбогдох тоо, мэдээллийг буруу мэдүүлэхийг хэлнэ. Үүнд хууль журмын дагуу декларацийн мэдүүлэг бөглөөгүйг мөн оруулна.

7. *худал мэдэгдэх* гэж авч явж буй мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийн дүнг буруу мэдэгдэх, эсхүл мэдэгдэл юмуу эрх бүхий албан тушаалтны асуултанд холбогдох тоо, мэдээллийг буруу мэдүүлэхийг хэлнэ. Үүнд хууль журмын дагуу мэдэгдээгүйг мөн оруулна.

8. *терроризмыг санхүүжүүлэх эсхүл мөнгө угаахтай холбоотойгоор* гэдгийг мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлтэй холбож тайлбарлахдаа дараах байдлаар авч үзнэ: мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэл гэж: (i) терроризм, террорист үйл ажиллагаа болон террорист байгууллагыг санхүүжүүлснээс олсон орлого, эсхүл санхүүжүүлэхэд ашигласан, ашиглахаар завдсан, зориулсан; (ii) мөнгө угаах гэмт хэрэг болон түүний үндсэн гэмт хэргээс олсон “угаасан” орлого, энэ гэмт хэргийг үйлдэхэд зориулсан болон завдсан хэрэгсэлүүд.

Бэлэн мөнгө тээвэрлэх асуудлыг шийдвэрлэхэд авч хэрэгжүүлэх арга хэрэгсэлүүд

9. Улс орнууд Тусгай Зөвлөмж IX болон энэхүү Тайлбарт заасны дагуу дараах аргуудын аль нэгийг авч хэрэгжүүлж болно. Гэхдээ мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр орох, гарах хоёр тохиолдолд заавал нэг ижил арга хэрэглэх албагүй.

а. *Декларацийн /мэдүүлэг бөглөх/ систем:* Мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр бэлнээр тээн нэвтэрч байгаа бүх зорчигч заасан хэмжээнээс дээш буюу 15,000 USD/EUR-аас /дээд хязгаар/ дээш дүнтэй мөнгө, төлбөрийн хэрэгсэлтэй явж байгаа бол эрх бүхий албан байгууллагад үнэнч шударгаар мэдүүлэг бөглөн өгөх үүрэгтэй. Энэ системийг хэрэглэж байгаа улс орнууд Тусгай Зөвлөмж IX-ийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд заавал мэдүүлэхээр заасан мөнгөний доод дүнг хангалттай бага тогтоох хэрэгтэй.

бусад холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэх талаар арга хэмжээ авч, тухайн хил нэвтрүүлэх үйлдлийн зорилго, чиглэл, эх үүсвэрийг тогтооход болон зохих арга хэмжээ авахад хамтарч ажиллах шаардлагатай.

- b. **Мэдэгдэх систем:** Мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр бэлнээр тээн нэвтэрч байгаа бүх зорчигч сайн дураараа эсхүл эрх бүхий албан байгууллагын шаардлагыг үндэслэн авч яваа мөнгө, төлбөрийн хэрэгсэлийн дүнг үнэнч шударгаар мэдэгдэх үүрэгтэй. Уг системийг хэрэгжүүлж байгаа үед эрх бүхий албан байгууллага нь авсан мэдээллийн дагуу болон сэжигтэй байж болзошгүй гэж үзсэний дагуу шалгах, мөн түүвэрчилж шалгалт хийх эрхтэй байх шаардлагатай.

Хоёр системд хамаарах нэмэлт мэдээлэл

10. Аль ч системийг хэрэглэсэн байсан, улс орнууд өөрийн хэрэглэж буй системийг дараах зүйлүүдтэй уялдуулсан байх шаардлагатай.
- a. Декларацийн/Мэдэгдэх систем нь мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хилээр оруулах, гаргах хоёуланд нь хяналт тавихад хэрэглэгдэж болно.
- b. Авч яваа мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг огт мэдүүлээгүй/мэдэгдээгүй, эсхүл худал ташаа мэдүүлснийг/мэдэгдсэнийг илрүүлсэн тохиолдолд эрх бүхий албан байгууллага нь уг мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийн гарал үүсэл, юунд хэрэглэхээр завдаж буй талаарх нэмэлт мэдээллийг зорчигчоос авах эрхтэй байна.
- c. Декларацийн/Мэдэгдэх системийн дагуу зорчигчоос авсан мэдээлэл нь Санхүүгийн мэдээллийн алба /СМА/-нд хүргэгддэг байх шаардлагатай. Хил дамнасан сэжиг бүхий тээвэрлэлтийн талаар СМА-нд мэдэгддэг систем, эсхүл мэдүүлэгээр өгсөн/мэдэгдсэн мэдээлэл нь өөр ямар нэг аргаар СМА-нд шууд хүрдэг системээр хангагдсан байх хэрэгтэй.
- d. Улс орнууд Тусгай Зөвлөмж IX-ийг хэрэгжүүлэх тал дээр дотоодын гааль, гадаадын харъяатын асуудал эрхэлсэн алба болон бусад холбогдох эрх бүхий байгууллагууд хамтарч ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлэх хэрэгтэй.
- e. Дараах хоёр нөхцөлд эрх бүхий албан байгууллага хилээр орж, гарч буй мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэл нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой эсэхийг шалгахын тулд тодорхой хугацаагаар зогсоох буюу саатуулах арга хэмжээ авч болно: (i) мөнгө угаах эсхүл терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэж байгаа тохиолдолд; (ii) худал мэдүүлэг өгсөн эсхүл худал мэдэгдсэн тохиолдолд.
- f. Декларацийн систем болон Мэдэгдэх систем нь Тусгай Зөвлөмж V болон Зөвлөмж 35-40-д тус тус заасанчлан олон улсын хамтын ажиллагаа, туслалцааг үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг байх шаардлагатай. Хамтын ажиллагааг дэмжих зорилгоор дараах тохиолдолд мэдээллийг эрх бүхий албан байгууллага ашиглахад зориулж хадгална: (i) мэдүүлгийн эсхүл мэдэгдлийн дүн 15,000 EUR/USD-оос их тохиолдолд, (ii) худал мэдүүлэг өгсөн эсхүл худал мэдэгдсэн тохиолдолд, (iii)

мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж сэжиглэж байгаа тохиолдолд. Эдгээр мэдээлэл дор хаяж дараах мэдээллийг агуулсан байна: (i) илрүүлсэн эсхүл мэдүүлсэн/мэдэгдсэн мөнгөн тэмдэгт, үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийн дүн; (ii) тэдгээрийг үзүүлэгчийн талаарх мэдээлэл.

Хариуцлага

11. Худал мэдүүлэг өгсөн эсхүл худал мэдэгдсэн зорчигчид эрүүгийн болоод захиргааны үр дүнтэй, тохирсон болон урьдчилан сэргийлэх шийтгэлийн арга хэмжээ ногдуулдаг байх шаардлагатай. Зорчигч мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаахтай холбоотойгоор хилээр бэлнээр тээн нэвтрүүлэхийг завдсан тохиолдолд мөн иргэний, эрүүгийн болоод захиргааны үр дүнтэй, тохирсон болон урьдчилан сэргийлэх шийтгэлийн арга хэмжээ ногдуулахаас гадна Зөвлөмж 3 болон Тусгай Зөвлөмж III-д заасантай нийцүүлэн тухайн мөнгөн тэмдэгт болон үзүүлэгчид шилжих төлбөр тооцооны хэрэгсэлийг хуулийн хүрээнд хураан авах арга хэмжээг авч хэрэгжүүлэх эрхтэй байх шаардлагатай.